



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 9 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 292

Улаанбаатар
хот


Тамирчин, дасгалжуулагчдад мөнгөн
шагнал олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 20.3.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "ТОКИО-2020" зуны XVI паралимпийн наадамд амжилттай оролцож, алтан медаль хүртсэн тамирчин Энхбаярын Содномпэлжээ, дасгалжуулагч Дашийн Баттулга нарыг 1 дүгээр хавсралтад заасан мөнгөн шагналаар шагнасугай.

2. Чөлөөт бөхийн залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, мөнгөн медаль хүртсэн тамирчин Батбаатарын Энхзул, хүрэл медаль хүртсэн тамирчин Мөнхбатын Мөнхгэрэл, дасгалжуулагч Паламын Чулуунбаатар, Түмэндэмбэрэлийн Сүхбаатар нарыг 2 дугаар хавсралтад заасан мөнгөн шагналаар шагнасугай.

3. Мөнгөн шагналд шаардагдах нийт 188,100,000.0 (нэг зуун наян найман сая нэг зуун мянган) төгрөгийг Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны батлагдсан төсвөөс зохих журмын дагуу гаргахыг Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц)-нд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга


Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2021 оны 292 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

"ТОКИО-2020" ЗУНЫ XVI ПАРАЛИМПИЙН НААДАМД АМЖИЛТТАЙ
ОРОЛЦОЖ МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИН, ДАСГАЛЖУУЛАГЧДАД
ОЛГОХ МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

(сая.төгрөг)										
№	Тамирчны нэрс	Жин, зай, төрөл	Медаль	Мөнгөн шагналын дүн	Тивийн оролцро	Тивийн оролцооны хувь	Тивийн хувь тооцсон мөнгөн дүн	Оролцсон орны тоо	Оролцсон орон тооцсон хувь	Тамирчинд (дасгалжуулагчид) олгох мөнгөн шагналын хэмжээ
"ТОКИО-2020" зуны XVI паралимпийн наадам ПАУЭРЛИФТИНГ-ийн төрөлд										
1.	Энхбаярын Содномпэлжээ	107 кг	Алт	120.000.000	-	100	120.000.000	-	100	120,000,000
2.	Дашийн Баттулга	Дасгалжуулагч							50	60,000,000
Нийт										180,000,000



Засгийн газрын 2021 оны 292 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**ЧӨЛӨӨТ БӨХИЙН ЗАЛУУЧУУДЫН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД
АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИН, ДАСГАЛЖУУЛАГЧДАД
ОЛГОХ МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ**

(сая.төгрөг)

№	Тамирчны нэрс	Жин, зай, төрөл	Медаль	Мөнгөн шагналын дүн	Тивийн оролцоо	Тивийн оролцооны хувь	Тивийн хувь тооцсон мөнгөн дүн	Оролцсон орны тоо	Оролцсон орон тооцсон хувь	Тамирчинд (дасгалжуулагчид) олгох мөнгөн шагналын хэмжээ
Чөлөөт бөхийн залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн ОХУ-ын УФА хот										
1.	Батбаатарын Энхзул	50 кг	Мөнгө	10.000.000	4	100	10.000.000	13	30	3,000,000
2.	Мөнхбатын Мөнхгэрэл	55 кг	Хүрэл	8.000.000	4	100	8.000.000	13	30	2,400,000
3.	Паламын Чулуунбаатар	Дасгалжуулагч							50	1,500,000
4.	Түмэндэмбэрэлийн Сүхбаатар									1,200,000
Нийт										8,100,000